

## Coming to terms with Buddhism

## 「За」

~Цовоо хариулж,цоглог өдрүүдийг өнгөрөөе ~

Та бүгд өдөр бүрийг хэрхэн өнгөрүүлж байна вэ?Нэгэнт л амьдарч байгаа болохоор гүнсгэр бүрхэг биш цовоо сэргэлэн байхыг хэн ч гэсэн хүсдэг биз ээ.Тэгвэл үүний тулд юунд анхаарвал зохих вэ?Хариу янз бүрээр байгаа боловч тэдгээрийн дотор зөв хэвшилтэй болох гэдэг нь чухал болов уу.

Зөв зан хэвшил гэвэл та бүгдэд өмнө нь танилцуулсан “өглөө оройны судар уншлага”, “хүнтэй мэндлэх” гээд байдаг билээ.Гэвч эдгээрийн дотор бас нэгэн их чухал зүйл бий.Энэ нь хүн өөрийг чинь дуудахад цовоо сэргэлэн дуугаар “За” гэж хариулж чадах явдал юм.”Өө, ердөө л ийм л юм байсан юм уу” гэж та бүгд бодож магадгүй.Гэвч үүнд хамгийн чухал нь “заавал” биелүүлж байх явдал юм.

Та бүхэн хэн нэгэн нь өөрийг чинь дуудахаар цоглогоор “За” гэж хариулж чаддаг үү?Их л хялбар зүйл мэт санагдах боловч үүнийг заавал биелүүлж байх ёстой гэхлээр хэцүү санагддаг.”За” гэж сайхан хэлэх хүн байвал,болж өгвөл дуугармаагүй хүн ч байдаг.Энэ нь өөрөө тэр хүнд дургүй,эсвэл санаа нийлдэггүй хүн ч байж болно.Мэдээж хэрэг тийм хүнтэй харьцах

хүсэлгүй гэдгийг сайвтар ойлгож байна.Гэвч яг тийм үед л нэг сайн тэвчих хэрэгтэй. Дургүй хүндээ ч гэсэн хүнлэг харьцана гэдэг нь өөрийнхөө зөрүүд зангаа дийлнэ гэсэн үг юм.Мөн “за” гэж хариулснаар хүнийг хүндлэх,хайрлах сэтгэлд хүргэнэ.

Ямар ч хүнд “За” гэж сайхан хариулна.Муухай царайлж хэлснээс сайхан инээмсэглээд хэлбэл бүр ч сайхан даа.Энэ бол тийм ч амар зүйл биш.Гэвч өдөр бүр давтан давтан хийснээр нэгэн сайхан зуршил болж амьдралаа илүү их гэрэл гэгээтэй,хөгжилтэй өнгөрүүлэх болно.



### Америкад сургаал түгээж эхэлсний 50-н жилийн ойн баярын арга хэмжээ боллоо



. Америкад сургаал түгээж эхэлсний 50-н жилийн ойн баярын арга хэмжээ 7-р сарын 31, 8-р сарын 1-ний өдөр Ласвегас хотноо зохион байгуулагдсан ба уг арга хэмжээнд РКК нийгэмлэгийн Ерөнхийлөгч болон Хавай, Лос Анжелас, Санфранциско, Нью Йорк, Оклахома, Сизтл, Чикаго, Сан Антониогоос ирсэн 630 орчим гишүүд оролцсон байна. Энэхүү арга хэмжээгээр Америкад сургаал түгсэн 50-н жилийн түүхийг өгүүлсэн баримтат киног үзүүлж, Нью Йорк нийгэмлэгийн гишүүн Жон Майкл Шүү өөрийнхөө туршлагаас хуваалцан илтгэл тавьсан байна. Мөн нийгэмлэг тус бүр дуу, бүжиг, жүжигчилсэн тоглолт зэргээр мэндчилгээ дэвшүүлсэн ба баярын танхим сэтгэл хөдлөл, инээд хөөрөөр дүүрэн байсан ажээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг Олон улсын хэлтсийн Хойд Америк хариуцсан төвийн дараах вэб хуудаснаас үзээрэй.

<http://www.buddhistcenter-rkina.org/>

# Лянхуа цэцэгтэй шиг

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч  
Нивано Ничикоу

## Лянхуа Цэцгийн сургаал

Лянхуа цэцэг нь шавар нуурын дотроос ямар ч толбогүй үзэсгэлэнтэйгээр дэлгэрч ургадаг гайхамшигтай цэцэг билээ. Энэхүү цэцгийн дүрсээс бид бүхэн буддын сургаалыг сурч авдаг билээ.

Лянхуа цэцгийн сургаал нь эрт дээр үеэс олон хүнийг эр зориг оруулж, амьдрах баяр баясгаланг олгож өгсөн юм.

Ялангуяа сургаалын доторх Дэвадатын тухай бүлэгт ямар ч муу хүн ч Буддын сургаалтай учрах аз завшаантай тааралдвал лянхуа цэцэгтэй адил шаварт хиртэх явдалгүй ариун гэгээний хүрээнд хүрч чадна гэж заасан байдаг нь их гүн утга учиртай.

Үүнийг бас өөрөөр тайлбарлавал, хүн ямар ч хүнд хэцүү байдалд орсон ч буддын сургаалыг сүсэглэн итгэвэл амьдрал тэр даруй өнгөө хувиргаж өөрчлөгдөнө гэсэн Буддын ухаан юм.

Лянхуа цэцэг нь маш богино амьдралтай билээ. Үүрээр цэцэглэн дэлгэрч, үдээс хойш гурван цагийн үед эргээд хаагдчихана. Үүнийг гурван өдөр үргэжлүүлж, дөрөв дэх өдөртөө цэцэглээд дуусдаг байна.

Лянхуа цэцэг гэхлээр би юуны өмнө шаврын өнгөнд хувирахгүй ариун сайхан дүрсийг болон буддын сургаалыг дүрсэлдэг.

Ямар ч үед зовлон байдаг. Гэвч хамгийн их зовлонтой байдаг үе цагт лянхуа цэцгийн утга учир нь хамгаас гүн байдаг болов уу гэж боддог.

## Цэцэгтэй адил байх

Лянхуа цэцэг нь сайхан цэцэглэхийн тулд шавар хэрэгтэй гэдэг. Энэ нь бид нарт чухам юуг хэлж байгаа болов оо?

Шавар нь ертөнцийн төрөл бүрийн муу муухай, зовлон гасланг илэрхийлдэг. Энэ бүгдэд живэхгүй, өнгөө хувиргахгүй байхыг лянхуа цэцгийн байдал нь илэрхийлдэг. Муллж буруутгамаар санагдах үйл явдал, өөрт таалагдахгүй зүйлийг “энэ бүхэн нь Буддагаас заяаж буй сургаал юм” гэж хүлээн авбал, тэр бүгд үнэхээр өөрийн чинь сэтгэлийн тэжээл болж, өсөн



хөгжих эрч хүч болдог. Будда бол ийнхүү лянхуа цэцгээр дамжуулан бидэнд сургаалаа дамжуулж байдаг юм.

Зовлон амсаж л хүний зовлонг ойлгоно. Бүтэлгүй явдал ба зовлон нь даруй сэтгэлийг зааж буй Буддын сургамж байж магадгүй юм. Өвчин нь бас одоогийн амьдралдаа баярлан талархах сэтгэлийг үүсгэн хөгжүүлдэг.

Өөрөөр хэлбэл, шавар дотор томоор цэцэглэн ургадаг лянхуа цэцэгтэй адил хүн зовж гачигдсанаас илүү их томоор өсөн хөгждөг байна.

Лянхуа цэцэг шиг амьдрахын тулд Буддын сургаалыг сайвтар сурч, бодисадвагийн мөрийг дагах хэрэгтэй. Тийм хүнийг дурсахад хамгийн түрүүнд сургаалын төлөө бие сэтгэлээ зориулсан Ничирэн гэгээн багш маань дурсагдах боловч багшийн мөрөөр дагах нь маш хүнд билээ.

Гэвч үүрийн туяагаар цацрагдсан лянхуа цэцэгтэй адил бид ч хүнтэй гэгээлэг сайхан сэтгэлээр хандаж, анхилуун сайхан үнэртэй нь адил хүмүүсийн сэтгэлд сайхан сийлэгхэн салхи үлээж явж чадна

Өдөр бүр цовоо сэргэлэн өнгөрөөе. Хүн бүр ийнхүү байвал нийгэм хөгжиж, хэн ч гэсэн аз жаргалтай болж чадна.

# Хүсэж төрдөгийн тухай

“Хүсэл”-ийн дагуу төрж ирдэг гэдгийн баталгаа Өмнөх хэсэг

Чичибү нийгэмлэг эмэгтэйчүүдийн дарга Магара Хироко

Энэхүү яриа нь 2009 оны 7 сарын 1-нд Ариун Их Ордонд болсон билээ 2 хувааж толинуулъя.

Би 1966 онд Бразилийн Томэас хотод Томита гэрийн бага охин болж төрсөн билээ.

Миний эцэг эх 1963 онд Бразилийг хөгжүүлэн дэвшүүлэх нүүдэлчин ард болж нүүдэлчдийн “Аргентина марү” усан онгоцонд суун Амазоны гүнд байрладаг Томэасүд нүүн орсон билээ.

Эцэг эх маань пимента гэдэг нуурны ургамлыг тарьж,яг тарианыхаа дээжийг хураан авах болсон үед аав маань элэгний хавдраар өвчилж,26 настайдаа нас барсан юм. 25 настай ээж маань,5 настай ах,2 настай эгч,төрөөд дөнгөж хагас жил болж байсан намайг аваад Япон уруу буцахаар болсон юм.Гэтэл буцах усан онгоц далайд гараад удаагүй байхад ээж 5 настай ахд түрийвчээ өгөөд,өөрөө далай уруу үсэрч хэзээ ч харьж ирэхгүй хүн болжээ.

Өнчирч үлдсэн хүүхэд бид нар олон хүний гараар дамжин нутагтаа хүрэлцэн ирж чадсан юм.Ах маань Точиги мужид байдаг ээжийн төрсөн гэрт,эгч бид хоёр Сайтама мужид байдаг аавын хамаатан эгчийн гэр бүлд үрчлэгдэн орсон юм.Хамаатан эгчийнхээ гэр бүлд хамгаалагдан өссөн ч,дунд сургуульд орох үед бас нэгэн хамаатан ахын гэрт үрчлэгдэн амьдрах болов.Багаасаа л “эцэг эхдээ хаягдсан хүүхэд”гэсэн бодолтойгоор өссөн болоод тэр үү,ямагт сэтгэл дундуур байлаа.

Ийнхүү би нөхөртэйгээ учраад 20 настайдаа хуримаа хийн сууж,нас барсан эцэг эхтэйгээ адил 3 хүүхэдтэй болсон юм.

Хуримаа хийгээд хэдэн жилийн дараа өөрийн байшин босгох болж,нөхрийнхөө хамаатан эгчийн зөвлөсний дагуу байшингийнхаа байршлийн зурхайг асуух гэж анх РКК-д ирсэн билээ.

Тэгээд тэр үед намайг хүлээн угтаж авсан нийгэмлэгийн дарга ба удирдагч багш нар миний амьдралын яриаг сонсоод эцэг эхийнхээ буяны төлөө гишүүнээр элсэхийг зөвлөсөн юм.Ороод удалгүй Чичибү нийгэмлэгийн 35 жилийн ойн баяр болж,надад өөрийнхөө амьдралын туршлагаас ярих

завшил олгодсон юм.

Тэр үед багшаар оролцон ирж байсан Нэцү Масүо дарга миний ярих илтгэлийн хуулбарыг Бразилийн нийгэмлэг үрүү явуулсан байсан юм.Ойн баярын өглөө Бразилээс ийм нэгэн факс ирсэн байв:

“Өнөөдрийн ойн баярт өөрийнхөө тухай ярих болсон Магара хатагтайг төрсөн нутаг болох Бразилийн олон ах дүүс нь халуун дэмжин хамгаалж байна.Хэзээ нэгэн цагт заавал Бразилд ирж,эцэг эхийнхээ сэтгэлийг тайвшруулан намдаахыг хүсэж байна.”Хаа байсан тэр хол газрын таньж мэдэхгүй сангагийн нөхдийн сайхан сэтгэлд үнэхээр баярласан.

Түүний дараа Бразилийн нийгэмлэгийн дарга Моримаэтай учирсан билээ.Аавын маань үлдээсэн юмны дотор нэгэн тооцооны бичиг байсан бөгөөд түүнийг Моримаэ даргад үзлэхэд:”Хүүхдийн сүүний тооцооны бичиг байна.Тур үед ойн гүнд амьдарч байсан ээж аавын чинь газарт юун хүүхдийн сүү байх төдий байлаа шүү дээ.Аав чинь хэдэн өдөр явж очдог холын Бэрэн хот хүртэл явж,хүүхдийн сүү авдаг байсан байна”гэж бичгийг орчуулан хэлсэн юм.Үүнийг сонсоод анх удаа эцэг эхийнхээ санаа сэтгэлийг мэдэрсэн юм.Шууд эцэг эхийнхээ нэртэй адислалыг хүртэж,ном уншдаг болов.Сургаалын гайхамшгийг бусад хүмүүст ч гэсэн дамжуулахсан гэсэн сэтгэлээр шашны даяанд идэвхтэй оролцсон билээ.Тэгээд эмэгтэйчүүдийн даргаар томилогдоод надтай адил олон эмэгтэйчүүдийн хайр тусламжийг хүртсэн юм.

4 жилийн өмнө Чичибү нийгэмлэг нь 45 жилийнхээ ойг тэмдэглэх үед би Сакаи Норио багштай танилцаж,тэрээр дараагаар Бразил айлчлах үедээ эцэг эхийн маань нойрсож буй газрын шороо,далайн уснаас авчирч өгсөн билээ.

Энэ явдлын ачаар 20 жил уулзаагүй ахтайгаа холбоо барьж,эгч дүү гурвуулаа уулзсан юм.Мөн Бразилийн нийгэмлэгийн даргад эцгийн булшыг олж өгөхийг гуйсан юм.Аавын маань шарил нь ойн гүнд булгагдаж,алга болсон гэж дуулж өссөн боловч жинхэнэ үнэнийг мэдэх цаг ирсэн юм.





【写真】

2008年、渡伯時。前列左から二番目が麻柄さん。

Үнэндээ бол аавын булш Томэасэд байрлагдаж байсан юм билээ.

Бразил дахь нийгэмлэгийн дарга Нагашима гуай биднийг төлөөлж, Сан-Паулогоос онгоцоор 3 цаг, дараагаар нь усан онгоц ба машинаар 6 цаг зарцуулж, эцгийн маань булш дээр очиж ном өргөн уншиж өгч агуу их буян үйлдэж өгсөн юм.

Мөн эцгийн булшыг 40 жилийн туршид харж хамгаалж байсан ээжийн талын хамаатан ах болох Мурои Хироши гэдэг хүн байдгийг ч мэдсэн.

Эцгийнхээ булшид очихсон гэсэн миний хүслийг хоёр талын нийгэмлэгийн дарга нар сайн мэдэж байсан тул би удалгүй Бразил явах болсон юм.

Үргэжлэл бий

遠い国から顔も知らぬ私を応援してくれる  
サンガとはなんと有難いのだろう





# Rissho Kosei-kai Overseas' Dharma Centers

# 2009

## Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

## Rissho Kosei-kai International of North America

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,  
CA 92612, U.S.A.  
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432  
e-mail: info@buddhistcenter-rkna.org http://www.buddhistcenter-rkna.org

## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.  
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633  
e-mail: info@mail.rkhawaii.org http://www.rkhawaii.org

### Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.  
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

### Rissho Kosei-kai Kona Branch

73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96750, U.S.A.  
Tel & Fax: 1-808-325-0015

## Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.  
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567  
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rk-la.com

### Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.  
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745  
e-mail: trina\_ozuna@juno.com

### Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

### Rissho Kosei-kai Buddhist Center of Denver

### Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

### Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.  
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-5569  
e-mail: rkksf@sbcglobal.net

### Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.  
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261  
e-mail: rkseattle@juno.com

### Rissho Kosei-kai of Sacramento

### Rissho Kosei-kai of San Jose

### Rissho Kosei-kai of Vancouver

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.  
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499  
e-mail: koseiny@aol.com

### Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.  
Tel & Fax: 1-847-394-0809  
e-mail: murakami3370@hotmail.com

## Rissho Kosei-kai of Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.  
Tel & Fax: 1-405-943-5030  
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

### Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls  
724 Main St. Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.  
Tel: 1-541-810-8127

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,  
CEP 04116-060, Brasil  
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304  
e-mail: hiromi\_mat@yahoo.com http://www.rkk.org.br

### Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,  
CEP 08730-000, Brasil  
Tel: 55-11-4724-8862

## Rissho Kosei-kai of Taipei

4F, No.10 Hengyang Road, Zhongjehng District, Taipei City 100  
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

### Rissho Kosei-kai of Taichung

No.19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,  
Taichung City 401  
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

### Rissho Kosei-kai of Jilung

## Rissho Kosei-kai of Tainan

No.45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701  
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

### Rissho Kosei-kai of Pingtung

No.4, Lane 60, Minquan Road, Pingtung City,  
Pingtung County 900  
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

## Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea  
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696  
e-mail: krkk1125@hotmail.com

### Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,  
Republic of Korea  
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

### Korean Rissho Kosei-kai of Masan

## Branches under the Headquarters

### Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,  
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic  
of China  
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

### Rissho Kosei-kai of Mongolia

39 Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,  
Ulaanbaatar, Mongolia  
Tel & Fax: 976-11-318667  
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

### Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amurskaya Street, Yuzhno-Sakhalinsk  
693000, the Russian Federation  
Tel & Fax: 7-4242-43-78-56

### Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland  
Tel: 41-22-791-6261 Fax: 41-22-710-2053  
e-mail: rkkgva@wcc-coe.org

### Rissho Kosei-kai of the UK

### Rissho Kosei-kai of Sydney

### Rissho Kosei-kai of Singapore

## International Buddhist Congregation (IBC)

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224  
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp http://www.ibc-rk.org/

## **Rissho Kosei-kai of South Asia Division**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1017 *Fax:* 81-3-5341-1224

### **Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218  
*e-mail:* thairissho@csloxinfo.com

### **Rissho Kosei-kai of Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel:* 880-31-2850238 *Fax:* 880-31-710572 (c/o Hotel Agrabad)  
*e-mail:* bimanrkkbimanrkk@yahoo.com

#### **Rissho Kosei-kai of Dhaka**

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,  
Dhaka Cant.-1206, Bangladesh  
*Tel:* 880-2-8316887

#### **Rissho Kosei-kai of Mayani**

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,  
Bangladesh

#### **Rissho Kosei-kai of Patiya**

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

#### **Rissho Kosei-kai of Domdama**

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

#### **Rissho Kosei-kai of Cox's Bazar**

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

#### **Rissho Kosei-kai of Satbaria**

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

#### **Rissho Kosei-kai of Laksham**

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

#### **Rissho Kosei-kai of Raozan**

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

### **Branches under the South Asia Division**

#### **Rissho Kosei-kai of Colombo**

No. 18 Anura Mawatha, Off Anderson Road, Kalubovila, Dehiwala,  
Sri Lanka  
*Tel:* 94-11-2763035 *Fax:* 94-11-4205632  
*e-mail:* rkksrilanka@visualnet.lk

#### **Rissho Kosei-kai of Polonnaruwa**

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,  
Sri Lanka

#### **Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

#### **Rissho Kosei-kai of Galle**

"Suwisal" Bataganwila, Imaduwa, Sri Lanka

#### **Rissho Kosei-kai of Kandy-wattegama**

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

#### **Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,  
New Delhi-110019, India  
*Tel:* 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713  
*e-mail:* sakusena@hotmail.com

#### **Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,  
KOLKATA 700094, India

#### **Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,  
Kathmandu, Nepal  
*Tel:* 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832  
*e-mail:* nrkk@wlink.com.np

### **Rissho Kosei-kai of Lumbini**

Shantiban, Lumbini, Nepal